



ДОРНОД АЙМАГ  
ЧОЙБАЛСАН СУМЫН ЗАСАГ ДАРГА

1 дүгээр баг, Хулстай, Чойбалсан сум, 21040  
Утас: 7058-6702

2024.05.01 № 1/138

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

Тус сумын 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ДОАЧБСЗДТГ/202401005 дугаартай “Гудамж тохижилт-3 /Хултай/” тендерийн ажил нь 2024 оны 04-р сарын 05-ны өдрөөс эхлэн 2024 оны 05-р сарын 06-ны 14 цаг 50 минутанд нээхээр тендер хүлээн авч байгаа болно.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4 зааснаар нийтийн эрх ашигт нийцээгүй, 60.3.6 зааснаар орон нутгийн иргэдийн саналыг аваагүй арга хэмжээг ИТХуралд өргөн мэдүүлж батлуулсан нь хуульд нийцэхгүй байгаа тул тендер нээх хуулийн хугацаанаас өмнө ДОАЧБСЗДТГ/202401005 дугаартай “Гудамж тохижилт-3 /Хултай/” тендерийг цуцлаж хүчингүй болгож өгнө үү



ДАРГА *П.Амгаланбаатар* П.АМГАЛАНБААТАР



ДОРНОД АЙМАГ  
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧИЙН  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 25-04-03.

Чойбалсан хот

Г Зөрчил арилгуулах, таслан зогсоох тухай <sup>1</sup>

Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн Дорнод аймгийн Чойбалсан сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлтөнд Ахлах дотоод аудитор, Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Мөнгөнтуул нар 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрөөс ажлын 20 хоногийн хугацаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитаар Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын хэрэгжилтийн байдлыг хянан шалгахад:

1. Орон нутгийн хөгжлийг дэмжсэн, иргэд, олон нийтийн саналыг авч эрэмбэлэгдсэн ажлуудыг багийн нийтийн хурлаараа өргөн мэдүүлэхээр хэлэлцсэн атлаа сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд төсвийг өргөн мэдүүлэхдээ иргэд, олон нийтээс олонхийн санал аваагүй, эрэмблэгдээгүй, өөрөөр хэлбэл Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4-д зааснаар нийтийн эрх ашигт нийцээгүй, 60.3.6-д зааснаар орон нутгийн иргэдийн саналыг аваагүй арга хэмжээг хуралд өргөн мэдүүлж, батлуулсан байна. Тухайлбал, 305,210.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Гудамж тохижилт-3 /Хулстай/” төсөл, арга хэмжээ нь багийн иргэдийн нийтийн хурлаар дэмжигдээгүй буюу /урьдчилсан саналаар 5 санал авсан/ хурлаас гарсан шийдвэрийн жагсаалтад байхгүй байхад 1 дүгээр багийн иргэдийн нийтийн хурлын 2023.06.27-ны өдрийн 2 дугаар тогтоолын хавсралтад /баталгаажаагүй/ уг ажлыг дэмжигдсэн гэж оруулж сумын Засаг даргад эрэмбийг хүргүүлсэн байна. Мөн 15,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “Гэмт халдлага, гамшгаас хамгаалах” төсөл эрэмблэгдээгүй байна.

2. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-д заасан “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх” гэснийг зөрчин 373,310.9 мянган төгрөгийн зураг, төсөвтэй “Гудамж тохижилт-3 /Хулстай/” ажлыг 68,100.0 мянган төгрөгөөр бууруулан хуралд өргөн мэдүүлж, батлуулсан байна.

3. Малын тоо толгойн албан татварын орлогын эх үүсвэрээр нөхөн төлбөр, урамшуулалд 720.0 мянган төгрөгийн санхүүжилт гаргахаар төлөвлөн баталсан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралт “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд дээрхи зөрчил дутагдлыг арилгуулах, дахин давтан гаргуулахгүй байх, зөрчлийг таслан зогсоох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг холбогдох дүрэм, журмын хүрээнд гүйцэтгүүлэхээр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8-д заасан “Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох,

2100006006

түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах”, мөн Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтооолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ын 7.5-д “санхүүгийн хяналт шалгалтын улсын /ахлах/ байцаагч нь шалгалтаар тогтоосон ажлын үр дүн, зөрчил түүнийг арилгах талаар цаашид авах арга хэмжээг тодорхойлсон шалгалтын тэмдэглэл, санхүү, төсөв, нягтлан бодох бүртгэлийн холбогдох хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны төлөх торгууль, төлбөрийг заасан нэг бүрчилсэн акт, албан шаардлага бичнэ”, Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Хяналт шалгалт хийх нийтлэг журам”-ын 28 дугаар зүйлийн 28.1-д “Улсын байцаагч хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах зорилгоор улсын байцаагчийн албан шаардлага үйлдэнэ” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.2.2, 60 дугаар зүйлийн 60.3.4, 60.3.6, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалтын хавсралт “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2, 4.5 дахь заалтуудыг зөрчин хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн тул дээрх төсөл, арга хэмжээг үргэлжлүүлэхгүй таслан зогсоох, төсвөөс санхүүжилт гаргахыг хориглох.

2. Аудитаар илэрсэн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, гарсан тохиолдолд нэн даруй алдааг запруулах талаар тодорхой ажил зохион байгуулж, Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д заасан “Байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан нь хяналт шалгалтын ажилд дэмжлэг туслалцаа үзүүлж, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, холбогдох арга хэмжээ авах талаар тавьсан шаардлагыг биелүүлж, дүнг тогтоосон хугацаанд нь албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй” гэсний дагуу албан шаардлагын биелэлтийг 2024 оны 05 дүгээр сарын 30-ний өдрийн дотор тус албанд албан бичгээр ирүүлэх.

3. Улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг биелүүлээгүй, хариуг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.3.6-д “санхүүгийн хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийг хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтанд хургуулэх” гэж заасны дагуу эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг хургуулэх болно.

**АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:**

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ *Б.Мөнгөнтуул* Б.МӨНГӨНТУУЛ

**ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:**

ЧОЙБАЛСАН СУМЫН ЗАСАГ ДАРГА *П.Амг* П.АМГАЛАНБААТАР

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА *Т.Тогтохцэрэн* Т.ТОГТОХЦЭРЭН

НЯГТЛАН БОДОГЧ *Г.Гандолгор* Г.ГАНДОЛГОР

